

ТӨВД ОРОН ХЭМЭЭХ НЭРИЙН ҮҮСЭЛ

Ш.ДОГМИЙЧОЙДОН

Эртний өлөгийг шинжлэн судлахад нэг мянган жилийн тэртээ Төвдийн өндөрлөгт хүн, амьтан оршиж байсан хийгээд анх ти /khri/ овгийн хүн амьдарч байсан цаг үе нь багцаалбал 8-5 мянган жилийн хооронд бөгөөд эдгээр нь өнөөгийн Төвд үндэстний өвөг мөн.

Уг овгийнхон 2000 жилийн өмнө Төвд орны өмнө зүгийн Ярлүн /Ялун/ мөрний дэргэдэх Ярлүн хошуунд тархсан бөгөөд МЭ-ний ҮШ зууны дунд үед Ярлүн хошууны зонхилогч Сронзан Гамбо нь Ярлүн нутгаас өнөөгийн Лхасад ирсэн хийгээд үүний дараа бусад аймгуудыг эзлэн хурааж Төвд орныг нэгдсэн улс болгож Тү-вход /thu-bhod/-ын хаанд өргөмжлөгджээ.

Энэ Төвд /bod/ хэмээхийг Хятадын түүхийн үе бүрд янз бүрээр дуудаж байсан бөгөөд Тан, Сүн улсын үед “Тү-вход” /thu-bhod/, Мин улсын үед “Вүй си зан” /dbus-si-gtsang/, Чин улсын үеэс эхлээд “Вод жон” /bod-ljong, Төвд орон/ гэж дуудах болсон.

Тан улсын үед Төвдүүд өөрсдийгөө “Вод” /bod, Төвд/ хэмээн нэрлэдэг байв. Тэгээд ч “Тү-вход” /thu-bhod/-ын түүхийг өгүүлсэн Хятадын эртний бичиг нь “Тан улсын нууц бичиг, Тү-вход /thu-bhod/-ын хаад” мөн бөгөөд тэнд өгүүлснээр Тү-вход /thu-bhod/ нь өнөөгийн “Вод жон” /bod-ljong/ буюу Төвд орон мөн гэдгийг үзүүлсэн хийгээд мөн “Тү-вход” /thu-bhod/ нь боолын байгууллын үед ихэд хүчирхэгжиж ойролцоох аймгуудыг эрхшээж Хөх нуур /Цинхай/, Сикан /Хам, khams/-ыг эзэлсэн учраас тэр үед “Тү-вход” /thu-bhod/-ын харъяанд багтсан Хөх нуурыг Төвдийн өндөрлөгийн хамт “Тү-вход” /thu-bhod/ хэмээн дуудах болсон гэжээ.

Тан улсын үед Хятад хэлэнд Төвдийг “fan” гэж бичсэнийг “во” хэмээн бичих болсон нь Зүг лаг хан /tsug-lag-khan, их хийд/ хийдийн өмнө Тан улсын үед байгуулсан “Бон шан” /dbon-zhang/ хөшөөний хятад, төвд бичгээр зэрэгцүүлэн бичиж дохио найруулах байдлаас “Pa” /ra/-г холбосон байна. Бас “Тү-вход” /thu-bhod/ нь ихэд хүчирхэг болсон үедээ өөрийн нутгаа томсгож Хөх нуур, Баруун Сикан зэргээр хязгаарлаж байжээ. Нэгдсэн Төвд нь 13 аймагтай бөгөөд өнөөгийн Аарий /mng'a-ris/, Үй зан /dbus-gtsang/, Хөх нуур, Ган лхо /kan-lho/, Ситон /si-khron/-гийн баруун хойд, Ганьзцы /dkar-mdzes/, Чамдо /chab-mdo/, Юньнань /yun-nan/, Дэчэн /bde-chen/ зэрэг болно.

¹ Ш.Догмийчойдон - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Юан улс байгуулагдсан хойно Төвд орон нь үнэхээр Хятадын захиргааны улс болж Юан улсын төв засгийн газрын нэгэн харьяат нутаг болжээ. Төвд орныг ерөнхийдөө засаг захиргааны гурван нэгжид хуваах бөгөөд До мад /mdo-smad/-ын харьяат өнөөгийн Хөх нуур, Ганьсу /kan-su'u/, Ситон /si-khron/-гийн баруун хойд хэсэг зэргийг төвд бичигт “Амдо” /a-mdo/ буюу хураангуйлж “До” /mdo/ хэмээн дуудах бөгөөд Юан, Мин улсын үед хятад бичигт “Дуо” /duo/ хэмээн хувирсан нэгдүгээр, До хам /mdo-khams/-ын харьяат өнөөгийн Ганьзцы /dkar-mdzes/, Дэчэн /bde-chen/, Чамдо /chab-mdo/ зэргийг төвд хэлэнд “Хам” /khams/ хэмээн дуудах бөгөөд Юан, Мин улсын үед хятад бичигт “Ган” /gan/ гэж бичигдсэн хоёрдугаар, Үй /dbus/, Зан /gtsang/, Аарий /mng'a-ris/ зэргийг төвд бичигт Вүй Зан /dbus-gtsang/ хэмээн дуудсан нь Юан, Мин улсын үед “Үй Зан” /dbus-gtsang/ гэж дуудагдсан гуравдугаар болой.

Чин улсын үед төвдийг “Тү-вхо-тү” /thu-bho-thu/, “Тан-гоү-ти” /thang-gou-thi/, “Нүв вод” /nub-bod, баруун төвд/ зэрэг гурван янзаар нэрлэж байсан үзэгддэг. Чин улсын хаан Жачины /ca-chin/ дараа бүгдээр нэгэн дуугаар “Нүв вод” /nub-bod, баруун төвд/ хэмээн нэрлэх болсон. “Нүв вод” /nub-bod, баруун төвд/ хэмээхийн “Нүв” /nub, баруун/ нь анх гарсан нутаг “Нүв” /nub, баруун/ оронд оршиж байсан төвд гэсэн утгыг агуулсан байна.

Өнөө үед Европ, Америк тивийн улс орнуудад төвдийг “tibat” хэмээн дуудах бөгөөд энэ нь арабын “tibbat” гэсэн бичигнээс гарсан байна. Манай эриний IX зууны дунд үе, Тан улсын доройтсон үед арабын нэгэн худалдаачин хятадад ирээд буцсан хойноо “Баруун зүгийн орны бичиг” хэмээхийг туурвисан бөгөөд түүнд өгүүлснээр “Тү-вход” /thu-bhod/ хэмээхийг “tibbat” /тү-вхо-тү, thu-bho-thu/ гэсэн хийгээд Германд хэвлэсэн “Японы түүхийн удирдлгал”-д араб хүмүүс төвдийг “tibet” гэж дуудах нь Тан улсын үед төвдийг “Тү-вход” /thu-bhod/ хэмээн дуудсанаас түгсэн юм гэжээ. Бас XIII зуунд Италийн жуулчин Марко Поло хятадад ирсэн бөгөөд тэрбээр франц хэлээр хэвлүүлсэн “Марко Пологийн бичиг” хэмээхэд төвдийг “Тү-вход-ти” /thu-bhod-thi/ гэсэн байдаг бөгөөд түүгээр ч франц хэлнээс авиа хувирч суларснаар “tibet” нь “Тү-вход” /thu-bhod/ хэмээхээс хувирсан юм” гэсэн ч буй.

Төвд хэлээр гардаг “Бодала” сэтгүүл. 1999 он. №4